

АЖИЛГҮЙДЭЛ, МЭРГЭЖИЛ СОНГОЛТ БА НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Wang Qinggeletu

Докторант

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

0009-0001-6739-4169

DOI: 10.66753/

W1720824674@gmail.com

Ч. Должинсүрэн

Доктор (Ph. D.), дэд профессор

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

0009-0004-1174-4221

DOI: 10.66753/

doljinsuren012@gmail.com

Хураангуй: Хөдөө орон нутгийн залуучуудын дунд ажилгүйдэл нэмэгдэж буй нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Энэхүү үзэгдэл нь зөвхөн ажлын байрны хомсдолоор хязгаарлагдахгүй бөгөөд мэргэжил сонголтын мэдээлэлгүй байдал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцээгүй боловсрол эзэмшсэн байдал, гэр бүлийн нөлөөлөл, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн хязгаарлагдмал бүтэц, нийгмийн ажлын үйлчилгээний хүртээмж сул зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байна. Иймд залуучуудын ажилгүйдлийг зөвхөн эдийн засгийн бус, нийгмийн оролцоо, карьер төлөвлөлт, нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй уялдуулан авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Түлхүүр үг: Ажилгүйдэл, мэргэжил сонголт, залуучуудын ажилгүйдэл, нийгмийн ажлын үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, орон нутаг

УДИРТГАЛ

Залуучуудын ажилгүйдэл нь орчин үеийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, боловсролын бодлогын огтлолцолд орших цогц нийгмийн асуудал юм. Ажилгүйдэл нь зөвхөн орлогогүй байдал бус, хувь хүний амьдралын чанар, сэтгэлзүйн тогтвортой байдал, нийгмийн оролцоо, ирээдүйн карьер төлөвшилд сөргөөр нөлөөлдөг бүтэц, нийгмийн шинжтэй үзэгдэл юм.

Монгол Улсад залуучуудын ажилгүйдэл нийт ажилгүйдлийн түвшнээс тогтмол өндөр хэвээр байгаа бөгөөд энэ нь ялангуяа хөдөө орон нутгийн залуусын хувьд илүү их илэрч байна. Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн шилжилт, боловсролоос хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх үйл явц

удаашралтай, тогтворгүй байгааг Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO) онцолсон байдаг.

Хөдөө орон нутгийн залуучуудын ажилгүйдэл нь зөвхөн ажлын байрны хүрэлцээгүй байдлаар тайлбарлагдахгүй бөгөөд мэргэжил сонголтын буруу шийдвэр, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүртээмжгүй байдал, гэр бүлийн нөлөөлөл, карьер төлөвлөлтийн сул байдал, нийгмийн ажлын үйлчилгээний хангалтгүй тогтолцоо зэрэг олон хүчин зүйлийн огтлолцлоор нөхцөлдөж байна. Иймд залуучуудын ажилгүйдлийг зөвхөн эдийн засгийн бус, нийгмийн ажлын онол, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх тогтолцооны хүрээнд авч үзэх шаардлагатай.

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Ажилгүйдэл, мэргэжил сонголт, нийгмийн ажлын үйлчилгээ нь хоорондоо уялдаа холбоотой, олон хүчин зүйлсийн нөлөөн дор бүрэлдэн тогтдог нийгмийн нийлмэл үзэгдэл юм. Иймд энэхүү судалгааг зөвхөн хөдөлмөрийн зах зээлийн эдийн засгийн үзүүлэлтээр бус, хувь хүний карьер төлөвлөлт, гэр бүлийн оролцоо, нийгмийн орчин, нийгмийн ажлын үйлчилгээний бүтэц, хүртээмжийн хүрээнд авч үзэх онолын шаардлага бий. Энэхүү судалгааны онолын үндэслэлийг ажилгүйдлийн онол, мэргэжил сонголтын онол, нийгмийн ажлын онолын гурван үндсэн хандлагад тулгуурлан авч үзэв. Юуны өмнө ажилгүйдлийг тайлбарлах онолын суурь нь энэхүү судалгааны үндсэн хүрээг тодорхойлж байна. Кейнсийн онолоор ажилгүйдэл нь эдийн засгийн нийт эрэлт буурснаас үүдэлтэй бөгөөд зах зээл өөрөө автоматаар тэнцвэрждэггүй тул төрөөс ажлын байрыг дэмжих бодлогоор зохицуулах шаардлагатай гэж үздэг (Keynes, 1936). Энэ нь орон нутагт ажлын байрны хомсдол, үйлдвэрлэл үйлчилгээний сул хөгжил, төрийн бодлогын оролцоо хангалтгүй байдал нь залуучуудын ажилгүйдэлд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах боломж олгож байна. Харин структур ажилгүйдлийн онолоор ажилгүйдэл нь хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ур чадвар болон ажил хайгчийн эзэмшсэн боловсрол, ур чадвар хоорондын зөрүүнээс үүсдэг гэж үздэг. Энэ нь хөдөө орон нутгийн залуус боловсрол эзэмшсэн хэдий ч тухайн орон нутагт мэргэжлээрээ ажиллах боломжгүй байгаа нөхцөл байдлыг тайлбарлахад илүү нийцтэй онолын тайлбар болж байна. Мөн Becker (1964)-ийн хүний капиталын онолоор боловсрол, ур чадвар, туршлага нь хөдөлмөрийн зах зээл дэх хувь хүний үнэ цэнийг тодорхойлдог боловч эдгээр нь зах зээлийн эрэлттэй нийцэхгүй тохиолдолд ажилгүйдэл үүсэх эрсдэл нэмэгддэг. Иймд боловсрол эзэмшсэн ч ажилгүй хэвээр байгаа залуучуудын нөхцөл байдлыг энэхүү онол тайлбарлах боломжтой.

Мэргэжил сонголтыг тайлбарлах онолын хувьд хувь хүний зан төлөв, сонирхол, гэр бүлийн оролцоо, нийгмийн нөлөөлөл, өөрийн үнэлэмж зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Holland (1997)-ийн мэргэжил сонголтын онолоор хувь хүний зан төлөв болон ажлын орчны нийцэл нь мэргэжлийн тогтвортой байдал, сэтгэл ханамжийг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, хувь хүний сонирхол, ур чадварт нийцээгүй мэргэжил сонгосон тохиолдолд тухайн хүн мэргэжлээрээ тогтвортой ажиллах, ажилдаа сэтгэл хангалуун байх боломж буурдаг. Энэхүү судалгаанд оролцогчдын дийлэнх нь мэргэжлээ гэр бүлийн нөлөө, бусдын жишиг, мэдээлэлгүй нөхцөлд сонгосон нь энэ онолын тайлбартай нийцэж байна. Super (1990)-ийн карьер хөгжлийн онолоор мэргэжил сонголт нь нэг удаагийн шийдвэр бус, амьдралын турш үргэлжлэх хөгжлийн процесс бөгөөд хувь хүний өөрийгөө танин мэдэх байдал, насны үе шат, нийгмийн орчны нөлөөллөөс шалтгаалдаг. Энэ нь залуучуудын мэргэжил сонголтод зөвхөн сургуулийн төгсөлтийн үеийн шийдвэр бус, өмнөх гэр бүлийн хүмүүжил, боловсролын туршлага, ирээдүйн хүлээлт зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг болохыг тайлбарлаж байна. Krumboltz (1979)-ийн нийгмийн суралцах онолоор мэргэжил сонголт нь хувь хүний суралцсан туршлага, орчны нөлөөлөл, гэр бүлийн үнэт зүйл, нийгмийн хүлээлтээс шууд хамаардаг. Судалгаанд оролцогчдын мэргэжил сонголтод эцэг эхийн оролцоо өндөр байгаа нь энэхүү онолын тайлбартай нийцэж байна. Харин Bandura (1986)-ийн өөртөө итгэх итгэлийн онолоор хувь хүний өөрийн чадварт итгэх итгэл нь шийдвэр гаргалт, карьер төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлтийн идэвхэд хүчтэй нөлөөлдөг. Удаан хугацаанд ажилгүй байх нь залуучуудын өөртөө итгэх итгэлийг сулруулж, ажил хайх идэвхийг бууруулах сөрөг нөлөө үзүүлдэг нь энэхүү судалгааны үр дүнтэй уялдаж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү судалгааны зорилго нь хөдөө орон нутагт амьдарч буй залуучуудын ажилгүйдлийн шалтгаан, мэргэжил сонголтод тулгарч буй асуудлуудыг тодорхойлох, мөн тэдгээрт чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгцээ, хүртээмжийг үнэлэхэд чиглэгдсэн болно. Судалгаанд тоон болон чанарын аргуудыг хослуулан ашигласан.

Судалгааны тоон мэдээллийг цуглуулах зорилгоор Орхон аймгийн 17–29 насны нийт 50 залуусаас санамсаргүй түүврийн аргаар стандартчилагдсан асуулгаар мэдээлэл авсан. Асуулга нь судалгааны зорилгод нийцүүлэн дараах үндсэн чиглэлүүдийг хамарсан. Үүнд: мэргэжил сонголтын үндэслэл, тухайн мэргэжлээр ажиллах боломж, ажилгүй байх хугацаа, орлогын эх үүсвэр, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чиг баримжаа, сургалтын хэрэгцээ зэргийг багтаасан.

Мөн судалгааны чанарын аргын хүрээнд тухайн бүс нутгуудад ажиллаж буй нийт 9 нийгмийн ажилтангаас залуусын ажилгүй байх болсон нөхцөл шалтгаан, мэргэжил сонголтод нөлөөлсөн хүчин зүйлс, нийгмийн үйлчилгээтэй харьцсан туршлага, хандлага, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан болно. Тус судалгаанд хамрагдсан оролцогчдыг хүйсээр нь авч үзвэл эрэгтэй оролцогчид дийлэнх буюу 58%-ийг эзэлж байна.

Мэргэжил сонголтын нөхцөл байдал

Судалгаанд оролцогчдын 60% нь мэргэжлээ сонгохдоо гэр бүлийн санал, эцэг эхийн шийдвэр, эсвэл бусдын жишээг дагасан хандлагаар шийдвэр гаргасан гэж хариулсан. Харин 24% нь сонирхол, ур чадвартаа тулгуурлан сонгосон бол ердөө 16% нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олдох магадлал зэргийг харгалзан үзсэн байна. Энэ нь залуучуудын дийлэнх нь мэргэжил сонгох үйл явцад мэдээлэл дутмаг байсныг харуулж байна.

Ажилгүй байх хугацаа ба шалтгаан

Судалгаанд оролцогчдын 68% нь 6 сараас дээш хугацаанд ажилгүй байгаа гэж хариулсан бөгөөд үүнээс 30% нь 1–3 жил ажилгүй байсан. Ажилгүй байх шалтгааныг дараах байдлаар тайлбарлаж байна:

- 42% нь “мэргэжилтэй боловч тухайн мэргэжлээрээ ажил олдоогүй” гэж хариулсан;
- 28% нь “мэргэжлийн үнэмлэх, дипломгүй” гэж хариулсан;
- 20% нь “ажил хийх хүсэлгүй, зорилгогүй” гэдгээ хүлээн зөвшөөрсөн;
- 10% нь “эрүүл мэндийн шалтгаан” гэх мэт хувийн нөхцөл байдлаа дурдсан.

Орлогын эх үүсвэр

Ажилгүй залуусын 52% нь гэр бүлийн эдийн засагт хамааралтай, 26% нь түр зуурын ажил хийдэг, харин 8% нь тэтгэмж эсвэл халамжийн хөтөлбөрөөс дэмжлэг авдаг гэжээ. Харин 14% нь огт орлогогүй гэж хариулсан.

Нийгмийн ажлын үйлчилгээний хүртээмж

Судалгаанд оролцогчдын 74% нь “нийгмийн ажилтан эсвэл хөдөлмөр халамжийн байгууллагаас ямар ч зөвлөгөө авч байгаагүй” гэж хариулсан бол 26% нь ямар нэгэн хэлбэрээр үйлчилгээ авч байсан ч үр дүнтэй байгаагүй хэмээн үнэлсэн. Мөн нийт судалгаанд оролцсон залуусын 86% нь “мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө авах хэрэгцээ бий” хэмээн тэмдэглэсэн.

Цаашдын хандлага ба хэрэгцээ

Оролцогчдын 58% нь “мэргэжлээ сольж, дахин суралцах хүсэлтэй” гэдгээ илэрхийлсэн бол 46% нь “өөрийн жижиг бизнес эрхлэх сонирхолтой” гэв. Гэвч дийлэнх нь “мэдээлэл, санхүүгийн дэмжлэг, зөвлөгөө дутагдаж байна” гэж тэмдэглэсэн.

Харин судалгаанд оролцсон нийгмийн ажилтнуудын хэлснээр залуусын дунд ажилгүйдэл газар авсан ч тэд нийгмийн үйлчилгээний талаар

мэдлэг багатай, эсвэл **огт хандаж үзээгүй** байх нь түгээмэл. Олон залуус зөвлөгөө, мэдээлэл авах шаардлагатай байдаг ч нийгмийн ажилтныг “зөвхөн халамжийн тэтгэмжийн бичиг баримт бүрдүүлдэг хүн” гэж ойлгодог.

Мөн ярилцлагад оролцсон ажилтнуудын хэлснээр, нийгмийн ажилтан нэг дор **олон чиг үүрэг хариуцдаг**, залуучуудад зориулсан тусгайлсан үйлчилгээ, хөтөлбөр бараг байдаггүй. Ингэснээр үйлчилгээний чанар, үр нөлөө сул байдаг байх хэмээн тайлбарлаж байсан.

Нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын үр дүнгээс харахад ажилгүй залуучуудад зориулсан нийгмийн үйлчилгээний хүртээмж, чиглэл, чанар хангалтгүй байгааг онцолсон. Мөн нийгмийн ажилтны ачаалал өндөр, дэмжлэгийн бүтэц дутмаг, тусгайлсан хөтөлбөрүүд хэрэгждэггүй нь энэ бүлгийн хэрэгцээг хангаж чадахгүй байгааг харуулж байна.

Энэхүү судалгаанаас харахад ажилгүйдэл нь зөвхөн ажлын байрны хомсдол бус, мэргэжил сонголтын буруу шийдвэр, мэдээлэлгүй байдал, нийгмийн ажлын үйлчилгээний сул хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй уялдаж байна. Нийгмийн ажилтны үйлчилгээ залуучуудын хэрэгцээнд бүрэн нийцэхгүй, зөвхөн халамжийн чиглэлд төвлөрсөн, чиг баримжаа өгөх, ажилд зуучлах, дахин сургах зэрэг идэвхтэй арга хэмжээг хэрэгжүүлдэггүй байна. Залуучууд ч нийгмийн ажилтны үүргийг буруугаар ойлгож, итгэлгүй, ханддаггүй байдал түгээмэл байна. Иймд ажилгүйдлийн шалтгааныг зөв оношлохын зэрэгцээ нийгмийн ажлын урьдчилан сэргийлэх, идэвхжүүлэх, чиг баримжаа өгөх чиглэлд системтэй ажиллах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнг нэгтгэсэн хүснэгт

Хүснэгт 1. Судалгааны үр дүнгийн нэгтгэл

Үзүүлэлт	Асуулгын судалгааны үр дүн (50 залуу)	Нийгмийн ажилтны ярилцлагаас гарсан дүгнэлт
Мэргэжил сонголт	60% нь мэдээлэлгүй, тохиолдлоор сонгосон	Мэргэжлийн чиг баримжаа өгөх үйлчилгээ бараг байхгүй
Ажил хайх хугацаа	76% нь ажил хайж буй; 28% нь 1 жил орчим хайсан	Ажилгүй залуусын дунд гутрал, итгэл алдрах байдал анзаарагддаг
Ажил хайхаа больсон хувь	24% нь ажил хайхаа больсон	Идэвхгүй байдал нэмэгдэх хандлага бий, дэмжлэг дутагдалтай
Нийгмийн үйлчилгээний хүртээмж	74% нь нийгмийн ажилтны үйлчилгээг авч үзээгүй	Хэрэглэгчид нийгмийн ажилтныг зөвхөн халамжийн үүрэгтэй гэж ойлгодог
Орлогын эх үүсвэр	52% нь гэр бүлээсээ хамааралтай	Орлогогүй байх нь залуусын идэвхийг улам бууруулдаг
Дахин суралцах сонирхол	58% нь сонирхолтой ч бололцоо дутмаг	Сургалт, чиг баримжаа, зөвлөгөөний бодит хөтөлбөр үгүйлэгдэж байна
Нийгмийн ажилтны ачаалал	-	Нэг ажилтан олон чиглэл хариуцдаг, залуучуудтай тусгайлсан ажил хийх боломжгүй
Сэтгэлзүйн дэмжлэг	-	Сэтгэлзүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх бүтэц байхгүй

Орхон аймгийн Насан туршийн боловсролын төв болон Орхон аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хамтран хэрэгжүүлж буй “Мэргэжил сонголт–амьдралын баталгаа” төсөл, хөтөлбөр нь ерөнхий

боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, өөрийн сонирхол, зан төлөв, ур чадвараа танин мэдэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд Е.А. Климов болон Ж. Холландын мэргэжил сонголтын онолд тулгуурласан хэв шинж тодорхойлох тест, оношилгоо ашиглан сурагчдын зан төлөв, сонирхол, чадварын онцлогийг тодорхойлж, түүнд нийцэх мэргэжлийн чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжил, шаардлагатай ур чадварын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажилладаг. Сүүлийн нэг жилийн хугацаанд тус хөтөлбөрт Орхон аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 500 гаруй сурагч хамрагдсан байна. Энэхүү судалгааны хүрээнд 2025 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан тус хөтөлбөрийн үйл ажиллагаанд өөрийн судалгааны ажлын хүрээнд ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөн оролцсон болно.

Ажиглалтын үр дүнгээс харахад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, төсөл хөтөлбөрүүд нь сурагчдад мэргэжлийн талаарх анхан шатны ойлголт, өөрийгөө танин мэдэх боломж олгож байгаа хэдий ч хэрэгжилтийн хувьд хэд хэдэн сул тал ажиглагдсан. Тухайлбал, сургалтын агуулга нь хүүхдэд төвлөрсөн боловч эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хангалтгүй, гэр бүлийн ойлголцол, сэтгэлзүйн зөвлөгөө, шийдвэр гаргалтын дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн сул байв. Үүний улмаас хүүхэд, эцэг эх, боловсролын байгууллагын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байж, сурагчийн оношилгоо, сонирхол, ур чадварт үндэслэсэн зөвлөмжийг эцэг эх хүлээн зөвшөөрөхгүй байх, улмаар мэргэжил сонголтын шийдвэрт зөрчил үүсэх нөхцөл ажиглагдсан.

Мөн хөтөлбөрийн хэрэгжилт нь сургалтад хамрагдсан хүүхдийн тоон үзүүлэлтээр үр дүнгээ хэмжих хандлагатай, харин сургалтын дараах эргэх холбоо, хяналт, шинжилгээ, үр нөлөөний үнэлгээ сул байгаа нь ажиглагдсан. Өөрөөр хэлбэл, сургалтад хамрагдсан сурагчид цаашид ямар мэргэжил сонгосон, зөвлөгөө нь шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлсөн, сонголт нь бодит үр дүнд хүрсэн эсэхийг дагаж үнэлэх тогтолцоо хангалтгүй байна. Энэ нь хөтөлбөрийн бодит үр нөлөөг үнэлэх, цаашдын сайжруулалтыг төлөвлөхөд хүндрэл учруулж байна. Иймд мэргэжлийн чиг баримжааны үйлчилгээг нэг удаагийн сургалт, оношилгоонд бус, шаталсан, системтэй, эргэх холбоотой, гэр бүл-сургууль-нийгмийн үйлчилгээний хамтын оролцоонд суурилсан цогц тогтолцоонд шилжүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн тус төслийн сургалтад хамрагдсан оролцогчдоос түүврийн аргаар 30 сурагчийг сонгон бүлгийн ярилцлага зохион байгуулж, сургалтын үр өгөөж, мэргэжил сонголтод үзүүлсэн нөлөө, гэр бүлийн оролцоо, шийдвэр гаргалтад тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулсан.

Ярилцлагын үр дүнгээс харахад “Мэргэжил сонголт–амьдралын баталгаа” төслийн хүрээнд зохион байгуулсан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, оношилгоо нь сурагчдад тодорхой хэмжээнд өөрийгөө танин мэдэх, сонирхол, зан төлөв, ур чадвараа тодорхойлох боломж олгосон эерэг талтай байв. Гэвч энэхүү сургалт нь мэргэжил сонголтын эцсийн шийдвэрт бүрэн нөлөөлж чаддаггүй, ялангуяа гэр бүлийн оролцоо, эцэг эхийн хандлагаас ихээхэн хамаарч байгааг ярилцлагын үр дүн харуулсан. Бүлгийн ярилцлагад оролцсон сурагчдын дийлэнх нь оношилгооны үр дүнгээ асран хамгаалагч, эцэг эхдээ танилцуулахад төдийлөн хүлээн зөвшөөрдөггүй, харин эцэг эхчүүд өөрсдийн хүсэл, үзэл бодол, туршлагад тулгуурлан хүүхдийн мэргэжил сонголтод нөлөөлөх, зарим тохиолдолд шууд тулгах хандлага түгээмэл байгааг онцолсон. Энэ нь мэргэжлийн чиг баримжааны үйлчилгээ зөвхөн хүүхдэд чиглэх бус, эцэг эх, асран хамгаалагчдыг хамарсан гэр бүлийн оролцоонд суурилсан цогц хэлбэрээр хэрэгжих шаардлагатайг харуулж байна.

Ийнхүү энэхүү судалгааны асуулгын болон ярилцлагын үр дүнг нэгтгэн, залуучуудын карьер төлөвлөлтийн байдлыг үнэлэх зорилгоор Career Readiness Vulnerability Index (CRVI) буюу Карьер төлөвшлийн эрсдэлийн нийлмэл индекс-ийг боловсруулсан. Энэхүү индекс нь залуучуудын мэргэжил сонголт, мэдээллийн хүртээмж, гэр бүлийн нөлөө, сэтгэлзүйн дэмжлэг, хувь хүний сонирхол зэрэг карьер төлөвшилд нөлөөлөх гол хүчин зүйлсийг нэгтгэн үнэлэхэд чиглэсэн болно.

CRVI нь нийт 0–6 хүртэлх онооны үнэлгээтэй бөгөөд өндөр оноо авах тусам тухайн оролцогчийн карьер төлөвшлийн эрсдэл өндөр, өөрөөр хэлбэл мэргэжил сонголтын хувьд эмзэг байдал нэмэгдэж байгааг илэрхийлнэ. Үзүүлэлтийг дараах байдлаар ангилсан. Үүнд:

- 0–1 оноо — карьер төлөвлөлтийн эрсдэл багатай
- 2–3 оноо — карьер төлөвлөлтийн дунд түвшний эрсдэлтэй
- 4–6 оноо — карьер төлөвлөлтийн өндөр эрсдэлтэй

Энэхүү индексийн үр дүнгээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь 4-өөс дээш оноо авч, карьер төлөвшлийн өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарч байгааг тогтоосон. Энэ нь тэд мэргэжлээ сонгохдоо хангалттай мэдээлэлгүй, гэр бүлийн нөлөөлөл өндөр, өөрийн сонирхол, ур чадвараа бүрэн танин мэдээгүй, сэтгэлзүйн болон мэргэжлийн зөвлөгөө авч байгаагүй зэрэг хүчин зүйлс карьерын шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлж байгааг илтгэж байна. Иймээс карьер төлөвлөлтийн эрсдэлийг бууруулахад зөвхөн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хангалтгүй бөгөөд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх, эцэг эхийн ойлголтыг сайжруулах, сэтгэлзүйн зөвлөгөө, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хувь хүний хөгжлийн дэмжлэгийг уялдуулсан цогц үйлчилгээ шаардлагатай байна.

Хүснэгт 2. Карьер төлөвшилийн эрсдэлийн түвшин

Үзүүлэлт	Тайлбар	Эрсдэлтэй гэж үзэх хариулт	Оноо
Эцэг эхийн оролцоо	Мэргэжил сонголтод оролцсон эсэх	Тийм	1
Мэргэжил сонголтод шууд нөлөөлсөн эсэх	Хүчтэй нөлөөтэй	Тийм	1
Өөрийн сонирхолд нийцсэн эсэх	"Бага", "Дунд" гэж хариулсан	Тийм	1
Мэдээлэлтэй байсан эсэх	"Үгүй" гэж хариулсан	Тийм	1
Эцэг эхийн боловсрол, мэргэжлийн нөлөө	"Их", "Дунд" гэж хариулсан	Тийм	1
Сэтгэлзүйн зөвлөгөө авсан эсэх	"Үгүй"	Тийм	1

Судалгаанд оролцогчдын 60% гаруй нь CRVI оноогоор 4-өөс дээш оноо авсан гэж тооцоход, залуучуудын карьер төлөвшил эрсдэлтэй түвшинд байгааг дүгнэж болно. Энэ нь Krumboltz-ийн нийгмийн суралцах онол, Super-ийн карьерийн хөгжлийн онол, мөн Bandura-ийн self-efficacy онолын хүрээнд баталгаажиг байна. Нийгмийн ажлын үйлчилгээ нь зөвхөн мэргэжил заах бус, сэтгэлзүйн зөвлөгөө, мэдээллийн хүртээмж, гэр бүлийн хамтын оролцоо зэргийг интеграцчилсан хандлагаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харахад хөдөө орон нутгийн залуучуудын ажилгүйдэл нь зөвхөн ажлын байрны хомсдолоос шалтгаалсан эдийн засгийн асуудал бус, харин мэргэжил сонголтын мэдээлэлгүй байдал, гэр бүлийн нөлөөлөл, хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, нийгмийн ажлын үйлчилгээний хүртээмж сул зэрэг олон хүчин зүйлийн нийлмэл үр дагавар болох нь тогтоогдлоо.

Нэгдүгээрт, мэргэжил сонголтын мэдээлэл, чиг баримжааны хүртээмж хангалтгүй байгаа нь залуучуудын ажилгүйдэлд шууд нөлөөлж байна. Судалгаанд оролцогчдын 62 хувь нь мэргэжлээ сонгохдоо хангалттай мэдээлэлгүй байсан гэж хариулсан нь боловсролын байгууллагууд болон нийгмийн үйлчилгээний байгууллагын зүгээс мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, карьер төлөвлөлтийн зөвлөгөөг системтэй хүргэж чадахгүй байгааг харуулж байна. Үүний улмаас залуучууд өөрийн сонирхол, ур чадвар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитоор үнэлэлгүйгээр мэргэжлээ сонгож, улмаар төгссөний дараа ажилгүйдэлд өртөх эрсдэл нэмэгдэж байна.

Хоёрдугаарт, мэргэжил сонголтод гэр бүлийн, ялангуяа эцэг эхийн оролцоо хүчтэй нөлөөлж байгаа нь залуучуудын карьерын шийдвэрт чухал хүчин зүйл болж байна. судалгаанд оролцогч нарын 70 хувь нь мэргэжил сонголтод эцэг эхийн санал шууд болон шууд бусаар нөлөөлсөн гэж хариулсан. Эцэг эхийн боловсрол, ажил мэргэжлийн туршлага нь хүүхдийн сонголтод тодорхой хэмжээнд чиглэл өгч байгаа боловч энэ нь бүх тохиолдолд хүүхдийн сонирхол, ур чадвар, хувь хүний онцлогт нийцэж чаддаггүй байна. Үүний улмаас хүүхэд өөрийн хүсэл сонирхлоос ангид, гаднын хүлээлтэд тулгуурласан сонголт хийх, улмаар мэргэжлээрээ тогтвортой ажиллах боломж буурах эрсдэл үүсэж байна.

Гуравдугаарт, нийгмийн ажлын үйлчилгээний хүртээмж, чиглэл нь залуучуудын хэрэгцээнд хангалттай нийцэхгүй байна. Орхон аймаг дахь нийгмийн ажлын үйлчилгээ нь гол төлөв эмзэг бүлгийн халамж, хамгааллын чиглэлд төвлөрч байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиг баримжаа, карьер төлөвлөлтөд чиглэсэн үйлчилгээ сул хөгжсөн байна. Судалгаанд оролцогчдын 80 хувь нь мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл өгөх үйлчилгээ авч байгаагүй гэж хариулсан нь залуучуудад зориулсан урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх, идэвхжүүлэх үйлчилгээ бодитоор дутмаг байгааг харуулж байна. Энэ нь нийгмийн ажлын үйлчилгээ залуучуудын ажилгүйдлийг бууруулахад бодитой нөлөө үзүүлж чадахгүй байгааг илтгэж байна.

Иймд хөдөө орон нутгийн залуучуудын ажилгүйдлийг бууруулахын тулд нийгмийн ажлын үйлчилгээг халамжид төвлөрсөн уламжлалт хэлбэрээс хөгжлийн чиг баримжаатай, урьдчилан сэргийлэх, идэвхжүүлэх тогтолцоо руу шилжүүлэх шаардлагатай байна. Үүний хүрээнд орон нутгийн нийгмийн ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, карьер хөгжлийн чиглэлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын түвшинд мэргэжлийн чиг баримжааны үйлчилгээг тогтолцоожуулах, залуучуудад дахин сургах, ур чадварын богино хугацааны сургалт, жижиг бизнес эхлүүлэх зөвлөгөө, санхүүгийн болон сэтгэлзүйн дэмжлэгийг цогцоор нь үзүүлэх шаардлагатай байна. Ийнхүү залуучуудын ажилгүйдлийг зөвхөн хөдөлмөрийн зах зээлийн асуудал бус, нийгмийн хөгжлийн бодлого, боловсролын тогтолцоо, гэр бүлийн оролцоо, нийгмийн ажлын үйлчилгээний уялдаа холбоонд суурилан шийдвэрлэх нь илүү үр дүнтэй юм. шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Bandura, A. (1986). Social Foundations of Thought and Action: A Social Cognitive Theory. Prentice-Hall.

2. Becker, G. S. (1964). *Human Capital: A Theoretical and Empirical Analysis*. University of Chicago Press.
3. Keynes, J. M. (1936). *The General Theory of Employment, Interest and Money*. Macmillan.
- International Labour Organization. (2017). *Jobs and Skills for Youth: Review of Policies for Youth Employment in Mongolia*. ILO.
4. International Labour Organization. (2024). *Global Employment Trends for Youth 2024*. ILO.
- International Labour Organization. (2023). *ILOSTAT Youth Labour Statistics*. ILO.
5. National Statistical Office of Mongolia. (2023). *Labour Force Survey 2023*. Ulaanbaatar.
6. Ministry of Labour and Social Protection of Mongolia. (2023). *Youth Employment and Labour Market Report*. Ulaanbaatar.
7. Болдмаа, Н., & Батжаргал, Н. (2024). Нийгмийн зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хийсэн социологийн шинжилгээ. *Социологи*, 14(2), 45–58.
8. Батбаатар, М., & Сономпил, О. (2024). Needs and Requirement of Social Work Development Policy in Mongolia. *Eurasia Forum of Social Workers*, 8(1), 22–31.